



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

С.Аригуунд чөлөө олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус ТУШААХ нь:

1. Тус албаны Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн Хог хаягдлын бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Саранхүүгийн Аригуун Удирдлагын академийн Төрийн алба, удирдлагын сургуулийн Төрийн захиргааны менежментээр мэргэшүүлэх дипломын Пүрэв гарагийн сургалтад суралцаж байгаа тул дотоод журмын 8 дугаар бүлгийн 8.7 дахь заалтын дагуу 2019 оны 01 дүгээр сарын 02-ноос 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийг дуутсал хугацаанд 7 хоногийн Пүрэв гараг бүрт ажлаас нь чөлөөлж, цалинтай чөлөө олгосугай.

2. Чөлөөтэй байх хугацаанд ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүрэг, цаг үеийн шаардлагатай өгсөн үүрэг даалгаврыг орлон ажиллах ажилтанд хариуцуулан өгч, эзэнжүүлж ажиллахыг ахлах мэргэжилтэн С.Аригуунд, үүрэгт ажилд нь хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Г.Ууганбаяр нарт тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

